

ГАРЧИГ

- 2-3** Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжих бэлтгэл ажил хийгдэж эхлээд байна
- 3-6** Зохицуулалтын мэдээ
- 7-8** М.Өлзийбат: Даатгалын салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар
- 9-11** Даатгалын багц дүрэм
- 11-13** Технологийн булан / Insurtech гэж юу вэ?
- 13** Даатгалын зах зээл мэргэжлийн шинжээчдийн нүдээр
- 14-15** Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо
- 15-16** Өргөн дуран
- 17** Даатгалын бүтээгдэхүүнийг олон нийтэд хэрхэн хүртээмжтэй хүргэх вэ?
- 18-20** “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” /MEFIN/ хөтөлбөрийн бүс нутгийн удирдах зөвлөлийн даргаар Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн ажиллаж байна
- 21** Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөл амжилттай хэрэгжиж дууслаа
- 22-23** Зах зээлийн мэдээ
- 23** Олон улсын даатгалын зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох нь
- 24** 2019 онд болох онцлох үйл явдлууд



М.Өлзийбат: ДААТГАЛЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦЭЖ БАЙГАА

Даатгалын салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга М.Өлзийбаттай ярилцлаа.

Даатгалын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг хэрхэн үнэлдэг вэ? Өнөөдөр даатгалын салбарт тулгамдаж буй гол асуудал юу вэ?

Манай улсын даатгалын салбар жилээс жилд тогтмол өсөлттэй байгаа. Тухайлбал, салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2018 оны эцсийн байдлаар 331.9 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 35.6 хувиар өссөн дүнтэй гарлаа. Нийт хураамжийн орлого 178.7 тэрбум төгрөг буюу 2017 оноос 23.8 хувиар өссөн байна. Хэдийгээр тасралтгүй өсөж байгаа ч гэлээ даатгалын салбарын хөгжлийн гол үзүүлэлтүүд тааруу хэвээр байна. Олон улсын жишгээр даатгалын хөгжлийн түвшинг гүнзгийрэлт, нягтрал гэсэн үзүүлэлтүүдээр хэмждэг. Даатгалын гүнзгийрэлт гэдэг нь хураамжийн нийт орлогыг ДНБ-д харьцуулсан, нягтрал гэдэг нь нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлогоор тооцсон үзүүлэлт юм. Манай улсын даатгалын гүнзгийрэлт 2017 оны байдлаар 0.56 хувь байгаа нь дэлхийн дунджаас 10 дахин бага, хөгжиж буй орнуудын дунджаас 5 дахин бага, харин даатгалын нягтрал ойролцоогоор 18.4 ам.доллартай тэнцүү байгаа нь дэлхийн дунджаас 35 дахин бага, хөгжиж буй орнуудын дунджаас 9 дахин бага байгаа юм.



ДААТГАЛЫН ХЯНАН ШАЛГАГЧДЫН ОЛОН УЛСЫН ХОЛБОО

International Association of Insurance Supervisors (IAIS) буюу Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо нь даатгалын салбарын зохицуулагч, хянан шалгагч нарын үүсгэн байгуулсан тус салбарт мөрдөгдөх стандартыг тогтоох чиг үүрэг бүхий ашгийн бус, сайн дурын гишүүнчлэл бүхий олон улсын байгууллага юм. Тус холбоо нь даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, даатгалын салбарыг зүй зохистой хөгжүүлэх, тухайн салбарын хяналт зохицуулалтыг тогтвортой, үр ашигтай байлгах зорилготой бөгөөд энэхүү зорилгын хүрээнд даатгалын салбарт мөрдөгдөх зарчим, стандарт, зөвлөмжийг батлан, тэдгээрийг мөрдүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

ДААТГАЛЫН ХЯНАН ШАЛГАГЧДЫН ОЛОН УЛСЫН ХОЛБООНЫ ҮҮСЭЛ

Тус холбооны үүсэл анх 1980-аад оноос National Association of Insurance Commissioners (NAIC) буюу Даатгалын зохицуулагчдын үндэсний холбооны жил бүрийн уулзалтад олон улсын даатгалын зохицуулагч нар оролцож эхэлснээс эхлэлтэй гэж хэлж болно.

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хороо товхимол

- 📍 Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IV байр.
- ☎ 976 51 261611
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.gov.mn
- 📍 Санхүүгийн зохицуулах хороо
- 📱 @FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ДААТГАЛЫН САЛБАРЫН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ НЬ:

Ил тод, нээлттэй, шударга, чөлөөт өрсөлдөөнт даатгалын зах зээлийг хөгжүүлэх

Даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг хямд, хялбар, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх

Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих, даатгалын компанийн эрсдэлийг тархаан байршуулж бууруулах

Эрсдэлийн удирдлага, хяналтын оновчтой тогтолцоо бүхий тогтвортой даатгалын зах зээлийг хөгжүүлэх



ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦООНД ШИЛЖИХ БЭЛТГЭЛ АЖИЛ ХИЙГДЭЖ ЭХЛЭЭД БАЙНА

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт “Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн удирдлагын зохицуулалтын тогтолцоог сайжруулна”, Санхүүгийн зохицуулах хорооны 2018–2021 оны стратеги төлөвлөгөөнд “Санхүүгийн зах зээлд оролцогч талуудын хооронд санхүүгийн эх үүсвэрийн үр ашигтай урсгалыг бий болгож, эрсдэлийн удирдлага, хяналтын оновчтой тогтолцоо бүхий тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ” гэж тусгагдсаны дагуу эрсдэлд суурилсан хяналт шалгалт руу шилжиж эхлээд байна.

Яагаад эрсдэлд суурилсан хяналт шалгалт руу шилжих ёстой вэ?

Уламжлалт хяналт шалгалттай харьцуулахад үр ашигтай: Олон улсад дампуурсан болон уналтад орсон компаниудын тохиолдлыг судалж үзэхэд хууль, дүрэм зөрчсөнөөс биш харин удирдлага, санхүүгийн хяналт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо сул,

компанийн засаглал хангалтгүй байгаагийн улмаас компаниуд дампуурч уналтад ордог байна.

Асуудлаас зайлсхийх боломжтой: Үүсч болзошгүй эрсдэлийг урьдчилан таньж мэдсэнээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой болдог.

Боломж, нөөцөө зөв зүйлд зарцуулах: Хяналт шалгалтын байгууллагын хүн хүчний нөөц бололцоо үргэлж дутмаг байдаг. Иймд энэхүү хязгаарлагдмал нөөц бололцоог өндөр эрсдэл бүхий санхүүгийн системд томоохон хохирол учруулахуйц зүйлд анхаарлаа хандуулах боломжийг олгодог.


Хяналт шалгалтын зохион байгуулалт сайжрах: Тогтсон арга, аргачлалаар эрсдэлийг үнэлэх боломжийг олгодог.

Хянан шалгагчийн ур чадвар, мэдлэгийг шаарддаг: Хянан шалгагч нь шаардлагатай мэдээллүүдийг цуглуулан чанарын үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийдэг.

Даатгагчийн эрсдэлийн удирдлага: Даатгагч нь эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар мэдээлэлтэй болдог.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо нь 3 тулгуур багана үзүүлэлтийг багтаадаг. Үүнд:

Solvency II



Тулгуур 1: Тоон үзүүлэлтийн шаардлага

- Даатгалын нөөц сангууд
- Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

Тулгуур 2: Хяналт шалгалт

- Эрсдэлийн удирдлага ба засаглал
- Даатгагчийн өөрийн эрсдэл ба төлбөрийн чадварын үнэлгээ
- Зохицуулагчийн хяналт шалгалт
- **Тулгуур 3: Мэдээллийн ил тод байдал** Санхүүгийн тайлан, нөхцөл, байдлын ил тод байдал
- Зах зээлийн ёс зүй, сахилга бат

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжих ажлыг шат дараалалтайгаар хэрэгжүүлэхийн тулд 1 дүгээр тулгуур багана үзүүлэлт буюу “Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал”, 2 дугаар тулгуур багана үзүүлэлт буюу “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх журам”, “Даатгагч өөрийн эрсдэл ба төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг тус тус боловсруулан Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2018 оны 290 дүгээр тушаалаар батлуулж, 2019 оноос туршилтаар хэрэгжүүлж эхлээд байна.

Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал

нь ердийн даатгал, урт хугацааны даатгал, давхар даатгалын компаниудын даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлох бөгөөд энэхүү аргачлалд тооцогдож байгаа эрсдэлүүдээс өөрөөр тоон утгаар илэрхийлэгдэж болох эрсдэлийг тооцох бололцоотой юм.

Энэхүү аргачлалыг ашигласнаар цаашид тооцож болох эрсдэлийн төрлийг нэмэгдүүлэх, даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн хүрэлцээтэй болон үнэн зөв байдлыг бий болгоход ач холбогдолтой.

Даатгалын компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих болон газар дээрх шалгалт хийх журам

нь Даатгалын тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн санхүү, төлбөрийн чадварын байдал, компанийн удирдлага, хяналтын орчин болон эрсдэлийн удирдлагын түвшинд үнэлэлт, дүгнэлт өгөх, даатгагчийн эрсдэлийн түвшинг тогтоох, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад оршино. Уг журмаар зайны хяналт болон газар дээрх шалгалтыг хэрэгжүүлэх арга, аргачлал болон тайлан боловсруулах загварыг тогтоож өгсөн.

Учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлох аргачлал нь зайны хяналт болон газар дээрх шалгалтын хувьд ялгаатай тодорхойлогдсон ба зайны хяналт хэрэгжүүлсний үр дүнд даатгагчид учирч болзошгүй эрсдэлийг тогтоож, газар дээрх шалгалтыг хэрэгжүүлэх хүрээг, тухайлбал даатгагчид ямар асуудал, эрсдэл тулгарч болзошгүй байгаад төвлөрч ажиллах боломж бүрдэх юм.

Даатгалын компани өөрийн эрсдэл ба төлбөрийн чадварыг үнэлэх аргачлалыг бий болгох нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцооны 2 дахь бүлэг үзүүлэлт буюу “Хяналт шалгалт” хэсэгт хамаарна.

Даатгагчийн хөрөнгийн үнэлгээний процесс нь бизнесийн төлөвлөлттэй маш нарийн уялдах ба даатгагч одоогийн эрсдэлийн багц, эрсдэлийн удирдлагын бодлого, хөрөнгийн чанар, түвшин нь зохицуулалтын хөрөнгийн шаардлагыг хангаж байгаа эсэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд одоогийн эрсдэлийн багцад гарч болох өөрчлөлтүүдийг үнэлэхийн тулд төсөвлөсөн эдийн засаг болон зохицуулалтын хөрөнгийг тодорхойлох замаар өөрийн ирээдүйн санхүүгийн байр суурийг тодорхойлох шаардлагатай. Даатгагч ирээдүйн төлбөрийн чадварын үнэлгээ хийхдээ даатгагчийн тогтоосон эрсдэл хүлээн авах сонирхолтой уялдуулсан бизнесийн олон жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийн хэрэгцээг тодорхойлно. Хэрвээ даатгагчид одоогийн болон төлөвлөсөн эрсдэлийн хөрөнгийн шаардлагыг хангах хэрэгцээтэй боломжит хөрөнгө чанарын болон тоон үзүүлэлтийн хувьд байхгүй бол даатгагч удирдлагын хэрэгжүүлэх хариу үйлдлийг тодорхойлох эсвэл хөрөнгийн хангалттай байдалтай холбогдох асуудлыг засварлах, эдгээр удирдлагын авч хэрэгжүүлэх ажилд бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, нэмэлт хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох зэрэг ажиллагааг хэрэгжүүлнэ.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ БА ТҮҮНИЙ ШИЙДВЭРЛЭЛТ

Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-т “Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Санхүүгийн зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно” гэж заасны дагуу 2019 оны I улирлын байдлаар Хороонд нийт 35 өргөдөл, гомдол ирсэн.

Улирал	2017.1	2017.2	2017.3	2017.4	2018.1	2018.2	2018.3	2018.4	2019.1
Өргөдлийн тоо	42	23	29	45	40	38	25	47	35

Тайлант хугацаанд даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 35 өргөдөл, гомдол ирсний хугацаандаа 28 нь шийдвэрлэгдсэн бол 7 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна. Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Д/д	Өргөдөл, гомдлын товч утга	2018/Тоо хэмжээ	Эзлэх хувь	2019/Тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	28	70%	29	82.9%
2	Нөхөн төлбөрийг дутуу олгосон	4	10%	4	11.4%
3	Нөхөн төлбөр олголтгүй удаасан	2	7.5%	2	5.7%
4	Даатгалын хураамжийн маргаан	2	5%	-	-
5	Бусад	3	7.5%	-	-
Нийт		40	100%	35	100%

Тайлант хугацааны даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр нь ангилбал:

Д/д	Даатгалын төрөл	2018/I тоо хэмжээ	Эзлэх хувь	2019/I тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Жолоочийн хариуцлагын даатгал	5	12.5%	9	25.7%
2	Тээврийн хэрэгслийн даатгал	13	32.5%	12	34.3%
3	Зээлдэгчийн эрсдэлийн даатгал	11	27.5%	8	22.8%
4	Гадаадад зорчигчдын гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1	2.5%	2	5.7%
5	Хөрөнгийн даатгал	3	7.5%	4	11.5%
6	Мал амьтны даатгал	3	7.5%	-	-
7	Ачаа, тээврийн даатгал	1	2.5%	-	-
8	Хариуцлагын даатгал	-	-	-	-
9	Санхүүгийн даатгал	-	-	-	-
10	Бусад	3	7.5%	-	-
Нийт		40	100%	35	100%

Даатгалтай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт дараах байдалтай байна:

Д/д	Өргөдлийг шийдвэрлэсэн утга	2019/I
1	Холбогдох этгээдэд албан бичгээр хариуг өгч шийдвэрлэсэн. Үүнээс	19
	Хорооноос үүрэг даалгавар хүргүүлсэн	13
	Хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн	6
2	Даатгагчийн гаргасан шийдвэр үндэслэлтэй	9
3	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	7
	Нийт	35

**ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ БОЛОН ЗУУЧЛАГЧИЙН СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА**

Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын мэргэжлийн холбоодтой байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний хүрээнд 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны өдрүүдэд 21-н аймагт даатгалын төлөөлөгчийн шалгалт, 2019 оны 3 дугаар сарын 21, 29-ний өдрүүдэд Урт хугацааны болон ердийн даатгалын төлөөлөгчийн шалгалт, 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр даатгалын зуучлагчийн шалгалтыг авч, дүнг Хорооноос сайтад байршуулж ажиллалаа.



**ХОРОО ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГАА УЛАМ
ӨРГӨЖҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА**

Эдийн засгийн интеграци эрчимтэй явагдаж буй даяаршлын энэ үед санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчны бодлого, зохицуулалтыг гадаад зах зээлүүдийн хөгжлийн хандлагатай нийцүүлэх асуудал улс бүрт тулгарч буй нийтлэг шаардлага болж байна.

Санхүүгийн зохицуулах хороо олон улсын санхүү, хөрөнгийн зах зээлийн интеграцид нэгдэх, гадаад хамтын ажиллагааны боломжуудыг дотоодын зах зээлд нээх, шударга өрсөлдөөнийг хангасан бизнесийн орчныг бүрдүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар Хороо Үнэт цаасны зохицуулагчдын олон улсын байгууллага (IOSCO), Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо (IAIS), Олон улсын хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын холбоо (ICURN), Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI) зэрэг олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, заримынх нь удирдах зөвлөл, мөн тодорхой чиг үүрэг бүхий дэд хороодод сонгогдон ажиллаж байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд бус нутгийн болон дэлхийн санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх стандарт, мөрдөх журам, үйл ажиллагааны зарчмыг боловсруулахад идэвхтэй оролцохын зэрэгцээ санхүүгийн зохицуулагчдын чадавхыг дээшлүүлэх бүх шатны сургалтад албан хаагчид, мэргэжилтнүүдийг тогтмол оролцуулж байна.

Дээрх нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудын удирдах зөвлөл болон дэд хороодод тодорхой хариуцлага хүлээн сонгогдон ажиллаж буй тул бодлого тодорхойлох болон үйл ажиллагааны чиглэлийг тогтоох хурал, дээд хэмжээний уулзалт зэрэгт Хорооны удирдлагууд эдгээр байгууллагын санхүүжилтээр оролцож ирлээ. Өнгөрөгч 2018 онд хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд ажил хэргийн 40 гаруй уулзалтад оролцож, 31 албан хаагч богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна. Тухайлбал, СХН-ийн ажлын хэсгүүдийн уулзалтад 23 албан хаагч оролцсоны дээр БНСУ-ын Санхүүгийн хянан шалгах байгууллагад 14 албан хаагч дадлагажиж, ОУВС-ийн Сингапур дахь Сургалтын төвийн мэргэшүүлэх сургалтад 5 албан хаагч хамрагджээ.

Хороо цаашид гадаад хамтын ажиллагаагаа бүхий л хэлбэрээр өргөжүүлэхээр ажиллаж байна.



**СХН-ИЙН АЖЛЫН ХЭСГҮҮД НОГООН САНХҮҮЖИЛТ БОЛОН
ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЛЭЭ**

Ногоон санхүүжилт буюу экологийн тэнцвэртэй хөгжлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудал өнөөдөр дэлхий дахины нэн тэргүүний зорилт болж байна. Өнгөрөгч долоон хоногт Бүгд Найрамдах Замби Улсын Ливингстон хотноо болсон олон улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (СХН, The Alliance for Financial Inclusion, AFI)-ийн “Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилт” (SMEF) ажлын хэсгийн 12 дахь, “Санхүүгийн хүртээмжийн стратегийн мэдлэг солилцох” (FIS) ажлын хэсгийн 14 дэх уулзалтуудаар энэ асуудлыг онцлон хөндсөн юм.

Санхүүгийн зохицуулах хороо СХН-ийн үйл ажиллагааны үндсэн бүтэц болох зургаан ажлын хэсэгт бүгдэд нь ажилладаг бөгөөд дээрх уулзалтуудаар гишүүн улс, орнуудад хэрэгжиж буй жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийн бодлого, туршлага, 2018 онд гарсан бодлогын өөрчлөлтүүд, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх стратегийг зөвлөлдөн ярилцсан юм. Уулзалтуудад оролцсон Хорооны мэргэжилтнүүд Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэгжиж байгаа ногоон санхүүжилт буюу тогтвортой хөгжлийн бодлогын талаар ажлын хэсгүүдэд танилцуулж, залуучууд, эмэгтэйчүүд зэрэг хүн амын бүлгүүд, алслагдсан нутагт санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүнийг сонголттой хүргэх талаар Хорооноос явуулж буй үйл ажиллагаа, зохицуулалтын талаар хэлэлцүүлээ.

Уулзалтуудад нийт 52 гишүүн байгууллагын 100 гаруй төлөөлөгч оролцсон бөгөөд “Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилт” (SMEF) ажлын хэсгээс гишүүн байгууллагууддаа тодорхой үүрэг, даалгавруудыг өгч, дээрх асуудлуудаар бодлогын баримт бичгийн төсөл боловсруулж, энэ оны наймдугаар сард багтаан СХН-т танилцуулахаар тогтсон юм. Харин “Санхүүгийн хүртээмжийн стратегийн мэдлэг солилцох ажлын хэсэг”-ийн хэлэлцүүлгийн үр дүнд дээрх асуудлууд болон албан бус секторыг албан сектор руу шилжүүлэх зэрэг хэд хэдэн чиглэлээр судалгаа, заавар зөвлөмж, гарын авлага боловсруулах дэд ажлын хэсгүүдийг байгууллаа. Эдгээр ажлын хэсгүүд нэг жилийн хугацаанд буюу дараагийн уулзалт хүртэл идэвхтэй ажиллаж, 2020 онд дуусгах юм.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДТОЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хороо нь Монголын даатгалын холбоотой “Хамтран ажиллах гэрээ”, Монголын банкны холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо болон Монголын хохирол үнэлэгчдийн холбоотой “Сургалт зохион байгуулах гэрээ”-г тус тус байгуулан ажиллаж байна.

Хороо хамтран ажиллах гэрээний хүрээнд даатгалын салбарын эрх зүйн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх, даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой судалгаа хийж зохицуулалтын орчинг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна даатгалын зах зээлд оролцогчид, тэдгээрийн боловсон хүчнийг чадавхжуулах зорилгоор сургалтын үйл ажиллагааг түлхүү явуулахаар гэрээнд тусгаад байгаа юм. Хороо даатгалын мэргэжлийн оролцогчдод эрх олгох болон мэргэшүүлэх сургалтыг мэргэжлийн түвшинд, чанартай зохион байгуулах, хяналт тавих зэрэг холбогдох чиг үүргийг Холбоодтой хамтран хэрэгжүүлж ажиллаж байна.



ДОТООДЫН ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРЧИМЖИЖ БАЙНА

Даатгалын компаниуд даатгуулагчтай байгуулсан даатгалын гэрээний үндсэн дээр хүлээж авсан эрсдэл буюу даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн давхар даатгалын компани руу дахин даатгуулдаг.

Сүүлийн 5 жилийн дунжийг авч үзвэл даатгалын компаниуд нийт даатгалын хураамжийн 31 орчим хувь буюу 158.3 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамж хэлбэрээр гадаадын давхар даатгагчид шилжүүлсэн байна. Гэтэл давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийн харьцааг сүүлийн 5 жилийн байдлаар харахад 14.1 тэрбум төгрөг буюу давхар даатгалын хураамжийн 9 орчим хувийг нөхөн төлүүлж байгаа нь харьцангуй доогуур үзүүлэлт юм.

2014 онд Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль батлагдсанаар манай улсын хамгийн анхны давхар даатгалын компани “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК байгуулагдах үндэс тавигдаж, 2015 онд

Санхүүгийн зохицуулах хорооноос давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон ба тус компани нь 2019 онд “Үндэсний давхар даатгал” ХК болгон нэрээ өөрчилсөн. Үүний дараа 2018 онд “Анд” ХХК давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бол мөн нэрээ өөрчилж “Хубилай давхар даатгал” ХХК болсон.

Ингэснээр манай улсад давхар даатгалын 2 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ нь гадаадын давхар даатгагчид шилжүүлж байгаа зарим хариуцлага, эрсдэлийг дотооддоо авч үлдэх, даатгалын компаниудын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж, гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах зэрэг давхар даатгалын тогтолцоонд ихээхэн эерэг өөрчлөлтийг авчрах төдийгүй цаашилбал, төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханшийн дарамт буурах зэрэг Монгол Улсын санхүү, эдийн засаг, даатгалын салбарт цөөнгүй эерэг нөлөө үзүүлнэ.



БАЙР СУУРЬ

М.Өлзийбат: Даатгалын салбарын эрх зүй, зохицуулалтын орчин олон улсын чиг хандлагад нийцэж байгаа

Даатгалын салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга М.Өлзийбаттай ярилцлаа.

Даатгалын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг хэрхэн үнэлдэг вэ? Өнөөдөр даатгалын салбарт тулгамдаж буй гол асуудал юу вэ?

Манай улсын даатгалын салбар жилээс жилд тогтмол өсөлттэй байгаа. Тухайлбал, салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2018 оны эцсийн байдлаар 331.9 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 35.6 хувиар өссөн дүнтэй гарлаа. Нийт хураамжийн орлого 178.7 тэрбум төгрөг буюу 2017 оноос 23.8 хувиар өссөн байна. Хэдийгээр тасралтгүй өсөж байгаа ч гэлээ даатгалын салбарын хөгжлийн гол үзүүлэлтүүд тааруу хэвээр байна. Олон улсын жишгээр даатгалын хөгжлийн түвшинг гүнзгийрэлт, нягтрал гэсэн үзүүлэлтүүдээр хэмждэг. Даатгалын гүнзгийрэлт гэдэг нь хураамжийн нийт орлогыг ДНБ-д харьцуулсан, нягтрал гэдэг нь нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлогоор тооцсон үзүүлэлт юм. Манай улсын даатгалын гүнзгийрэлт 2017 оны байдлаар 0.56 хувь байгаа нь дэлхийн дунджаас 10 дахин бага, хөгжиж буй орнуудын дунджаас 5 дахин бага, харин даатгалын нягтрал ойролцоогоор 18.4 ам.доллартай тэнцүү байгаа нь дэлхийн дунджаас 35 дахин бага, хөгжиж буй орнуудын дунджаас 9 дахин бага байгаа юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь Даатгалын хянан шалгагчдын Олон Улсын холбооны гишүүн байгууллагынхаа хувьд Олон улсын жишигт нийцсэн зохицуулалтыг бий болгох, даатгалын салбарт оролцогчдын чадавхыг

бэхжүүлэх замаар даатгалын салбарын өсөлтийг хангах бодлого явуулж байна. 2018 онд Хорооноос хийсэн “Монгол Улсын санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг үнэлэх” судалгааны үр дүнгээс харахад нийт иргэдийн 94.5 хувь нь ямар нэгэн байдлаар албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагддаг хэдий ч тэдний 70 хувь нь сайн дурын даатгалд хамрагддаггүй гэсэн дүн гарсан. Энэ нь манай улсад даатгалын хүртээмж хангалтгүй байгааг илтгэж байна.

Даатгалын салбар цаашид зах зээлээ тэлэх боломжтой юу?

Монголын даатгалын гүнзгийрэлт олон улсын дунджаас 10 гаруй дахин бага байгааг би сая хэллээ. Энэ бол манай даатгалын зах зээл 10 дахин тэлэх боломжтой юм. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг цаашид нэмэгдүүлэх нэг гол хүчин зүйл бол иргэдийн санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, даатгалын соёл, даатгагдах хэв зуршлыг төлөвшүүлэх явдал юм. Тиймд Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголбанк хамтран 2021 он хүртэлх “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг батлан, хэрэгжүүлж байна.

Монголын даатгалын компаниудын эрсдэл даах чадвар ямар түвшинд байгаа гэж үзэж байна вэ?

Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын компанид учирч болох эрсдэлийг урьдчилан таамаглаж тогтоох, урьдчилан сэргийлэх зорилгоор тавих хяналтыг боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Дэлхийн эдийн засгийн хямралуудыг авч үзвэл зохицуулагч байгууллагууд даатгагчийн бизнесийн үйл ажиллагаатай холбогдох эрсдэлээс гадна системийн эрсдэлийг анхаарч үзсэн байдаг ч хяналт, шалгалтын уламжлалт арга ажиллагаа нь болзошгүй санхүүгийн хүндрэлээс сэргийлэхүйцээр эрсдэлийг үнэлж, удирдах хангалттай хэрэгсэл байж чадахгүй байсан. Өөрөөр хэлбэл даатгагчийн үйл ажиллагаанд ирээдүйд учирч болох эрсдэл нь тэдний санхүүгийн чадвар болон бусад чадавхад хэрхэн нөлөөлөх талаар тооцоолж, харуулж чаддаггүй. Цаашилбал, энэ уламжлалт хандлага нь даатгагчийн үйл ажиллагаанд ноцтой хохирол учруулахааргүй материаллаг бус зүйлсэд анхаарал хандуулж, цаг их зарцуулдаг, мөн нөгөөтэйгүүр даатгагчийн санхүүгийн чадавх, үйл ажиллагааны хүрээнд хүндрэл учруулж болзошгүй, эрсдэл өндөртэй үйл ажиллагааг орхигдуулж, улмаар хожуу мэдсэн тохиолдолд хариу арга хэмжээ авахад бэрхшээл үүсгэдэг байна. Ерөнхийдөө эрсдэлд суурилсан хяналт шалгалтын гол зорилго нь даатгагчийн үйл ажиллагаанд эрсдэл учирсных нь дараа бус эрсдэл учрахаас нь өмнө олж мэдэж, урьдчилан сэргийлэх боломж олгодгоороо давуу юм.

Даатгалын салбарын эрх зүй, зохицуулалтын орчин ямар байна вэ?

Даатгалын салбарын хуулиуд, мөн Хорооноос батлан мөрдүүлж байгаа журам, дүрмүүд харьцангуй Олон улсын туршилтад үндэслэсэн, даатгалын зах зээлийн хөгжлийн чиг хандлагад нийцэж байгааг дурдах хэрэгтэй. Гэхдээ Монгол Улсын даатгалын салбарын бүтэц хөгжингүй улс орны жишигтэй харьцуулахад маш их ялгаатай байна. Хөгжингүй улсуудын даатгалын салбарын бүтэцэд урт хугацааны даатгал ихэнх буюу 50–иас дээш хувийг эзэлдэг бол манай улсад ердөө ганц урт хугацааны даатгалын компани байна. Энэ компани 2018 оны байдлаар даатгалын салбарын нийт хураамжийн орлогын ердөө 1.0 хувийг бүрдүүлсэн. Үүнд манай өнөөгийн нийгмийн даатгалын тогтолцоо шууд нөлөөлж байна. Иймд даатгалын салбар, тэр дундаа урт хугацааны даатгалын салбарыг хөгжүүлэхийн тулд Даатгалын тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулахаар судалж эхлээд байна. Мөн даатгалын компаниуд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагч хэлбэрээр оролцож, хөрөнгийн зах зээлийн эрэлт, хөрвөх чадварыг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байгаа. Иймд Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах талаар Сангийн яам болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөлөлтэй хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Даатгалын компаниудын үйлчилгээ ихэнхдээ ижил төстэй байдаг ба төрөлжиж ялгарч чаддаггүй. Тухайлбал, компаниуд хөдөө аж ахуй, уул уурхай, зам тээврийн гэх зэрэг чиглэлээр үйлчилгээгээ төрөлжүүлэх боломжтой юу?

Боломжтой. Даатгалын тухай хууль тогтоомжид энэ талаар ямар нэгэн хориглосон заалт байхгүй бөгөөд үйлчилгээгээ төрөлжүүлэх нь даатгагч нарт нээлттэй.

Монголын даатгалын компаниуд экспортын даатгал хийх боломжтой юу?

Манай даатгалын компаниуд зах зээлийн орон зай, нөөц бололцоогоо улам тэлсээр

байна. Ямар чиглэл, салбарт ямар бүтээгдэхүүн гаргаж ажиллах вэ гэдэг нь компаниудын бизнесийн асуудал. Одоогоор экспортын даатгал хийж буй даатгалын компани байхгүй. Энэ орон зайг боломжтой, ашигтай гэж үзвэл компаниуд ажиллах л байх.

Үндэсний давхар даатгалын компани байгуулагдсан нь Монголын даатгалын салбарын хөгжилд ямар ач холбогдолтой гэж үзэж байна вэ. Давхар даатгал манай улсад хэр хөгжиж байгаа вэ?

Манай улсад өнөөдрийн байдлаар давхар даатгалын хоёр компани байна. Нэг нь төрийн, нөгөө нь хувийн өмчийнх. Дотоодын компаниуд давхар даатгалын үйл ажиллагаа явуулснаар гадаадын давхар даатгагчид шилжүүлж байгаа зарим хариуцлага, эрсдэлийг дотооддоо авч үлдэх, даатгалын компаниудын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж, гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах боломжтой.

Даатгалын компаниуд IPO гаргаж эхэллээ. Энэ нь Монголын даатгалын салбарын хөгжилд хэрхэн нөлөөлнө гэж та үзэж байна вэ?

Даатгалын салбарын хоёр компани IPO гаргаад байна. Энэ нь даатгалын салбарын хөгжилд томоохон хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Тухайлбал, компанийн засаглал сайжирч, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал нэмэгдэнэ. Мөн түүнчлэн хяналт, зохицуулалтын шинэ нөхцөл шаардлага бий болоод байгаа.

Ойрын таван жилийн хугацаанд даатгалын салбарын хөгжил ямар түвшинд хүрэх боломжтой вэ?

Санхүүгийн зохицуулах хороо нь бодлого, стратеги, үйл ажиллагаандаа Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, Монгол Улсын засгийн газрын 2017 оны 229 дүгээр тогтоол, 2016 оны 8 дугаар тогтоолоор тус тус баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Эдийн засгийг сэргээх нарийвчилсан төлөвлөгөө” зэрэг бодлогын

баримт бичгийг баримталж ажилладаг ба эдгээрт тулгуурлан Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 310 дугаар тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооны 2018–2021 оны стратеги төлөвлөгөө”-г батлан, үүндээ даатгалын салбарыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөөг тусгасан байдаг. Энэхүү стратеги төлөвлөгөөнд тусгагдсан томоохон ажлуудаас дурдвал, үндэсний давхар даатгалын тогтолцоог бүрдүүлэх, даатгалын салбарын холбогдох хуулиудыг шинэчилж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн удирдлагын зохицуулалтын орчинг бий болгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн тогтолцоог сайжруулах, иргэдийн даатгалын боловсрол, суурь мэдлэгийг дээшлүүлэх зэргийг дурдаж болно.



ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

ДААТГАЛЫН БАГЦ ДҮРЭМ

Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Хорооноос батлан мөрдүүлж буй хэм хэмжээ тогтоосон захиргааны актуудыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлснээр хүчин төгөлдөр болохоор хуульчилсан.

Даатгалын тухай болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан “Даатгалын багц дүрэм”, бусад журам, зааврын төслийг боловсруулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийг баталж, 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдүүлж эхэлсэн.

Даатгалын багц дүрэм дараах дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлагаас бүрдсэн болно. Үүнд:

1. Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт;
2. Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам;
3. Даатгалын нөөц сан албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам;
4. Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага;
5. Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал;
6. Даатгалын үнэлгээ хийх аргачлал;
7. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудиторт тавигдах нөхцөл, шаардлага;
8. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам;
9. Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага;
10. Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага;
11. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тайлан мэдээ гаргах, санхүүгийн тайлангийн агуулга, маягыг тогтоох журам;
12. Даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журам;
13. Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага;
14. Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулиас гадуур даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах журам;
15. Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл;
16. Даатгалтай холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар;
17. Энэ хуульд заасан мэдээллийг хэвлэн нийтлэх журам.

ҮНЭТ ЦААСНЫ БАГЦ ДҮРЭМ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг Хорооноос баталсан багц дүрмээр зохицуулна.” гэж заасан байдаг ба 26.2 дахь хэсэгт зааснаар энэхүү багц дүрэм нь нийт 14 дүрэм, журам, аргачлал, заавраас бүрдэх юм. Иймд тус багц дүрмийг боловсруулах хүрээнд дээрх 14 харилцааг дараах байдлаар нэгтгэн 5 журам болгон багцалсан.

- I. Багц дүрмийн нэгдүгээр хавсралт болох “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”:
1. Тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам болон түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (ҮЦЗЗТХ-ийн 26.2.1);
2. Харилцагчид үйлчилгээ үзүүлэх, түүнийг баримтжуулах (ҮЦЗЗТХ-ийн 26.2.7);
3. Зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтныг томилох, тохиромжтой этгээдийг тодорхойлох (ҮЦЗЗТХ-ийн 26.2.9);
4. Зохицуулалттай этгээдийн архивын баримт бүрдүүлэх, хадгалах, шилжүүлэх (ҮЦЗЗТХ-ийн 26.2.10);
5. Зохицуулалттай этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нээх, тэдгээрт тавих нөхцөл, шаардлагыг тодорхойлох (ҮЦЗЗТХ-ийн 26.2.12);
- II. Багц дүрмийн хоёрдугаар хавсралт болох “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам”:
6. Зохицуулалттай этгээдэд тавих нөхцөл, шаардлага, тэдгээрийн төлбөрийн чадварыг тодорхойлох аргачлал, шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих (ҮЦЗЗТХ-ийн 26.2.2);
- III. Багц дүрмийн гуравдугаар хавсралт болох “Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн журам”:
7. Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд хяналт тавих (ҮЦЗЗТХ-ийн 26.2.3);
- IV. Багц дүрмийн дөрөвдүгээр хавсралт болох “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”:
8. Хуульд заасан мэдээллийг Хороонд хүргүүлэх, нийтэд мэдээлэх, түүнд хяналт тавих (ҮЦЗЗТХ-ийн 26.2.5);
9. Зохицуулалттай этгээдээс Хороонд мэдээ, тайлан гаргах (ҮЦЗЗТХ-ийн 26.2.11);

10. Зохицуулалттай этгээдээс түүнтэй холбогдох этгээдийн талаар Хороонд мэдээлэл ирүүлэх, уг мэдээллийг нийтэд мэдээлэх (ҮЦЗЗТХ–ийн 26.2.14);
- V. Багц дүрмийн тавдугаар хавсралт болох “Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах журам”:
11. Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах (ҮЦЗЗТХ–ийн 26.2.6);
12. Харилцагчийн даалгаврыг хүлээж авах, биелүүлэх үйл ажиллагааг арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны тооцооны байгууллага өөрийн дотоод журмаар зохицуулах асуудал тул;
13. Зохицуулалттай этгээдээс төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох асуудал нь Хорооны 2015 оны 158 дугаар тогтоолоор нэгдсэн байдлаар зохицуулагдаж байгаа тул;
14. Хуульд өөрөөр заагаагүй бол зохицуулалттай этгээдийн үйлчилгээний хураамж, шимтгэлийн дээд хязгаарыг тогтоох асуудал нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдан өөрчлөгдөх шаардлагатай зохицуулалт тул Хорооны тогтоолоор тогтоогдож байгаа өнөөгийн арга хэлбэрийг үргэлжлүүлэх зорилгоор багц дүрэмд тус тус тусгаагүй болно.

Энэ багц дүрмээр үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагааг эрхэлж буй хуулийн этгээдүүдэд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх, үүнтэй холбогдон тэдгээрт тавигдах шаардлага, шалгуурыг тогтоох, зохицуулалттай этгээд болсны дараах үйл ажиллагаанд тавигдах, дагаж мөрдөгдөх хяналт, зохицуулалтын харилцаа, тэдгээрийн дотоод үйл ажиллагаа, удирдлагын хариуцлагаас үүдэлтэй эрсдэлийг хаах арга зам, мэдээлэл, тайлагналын асуудал, зар сурталчилгаанд тавигдах хяналт зэрэг цогц үйл ажиллагааг зохицуулах юм.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ДААТГАЛЫН ТАЛААР ИРГЭД, ДААТГУУЛАГЧДАД ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн зохицуулах хороо даатгалын үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, зохицуулалтыг сайжруулах зорилгоор олон улсын практикийн дагуу зээлдэгчид болон банкиг эрсдэлээс хамгаалахад чиглэсэн

орон сууцны ипотекийн зээлийн даатгалыг оновчтой хэлбэрээр бий болгон, шинээр нэвтрүүлээд байна. Энэхүү даатгалын шинэ бүтээгдэхүүний зохицуулалтын журам болох “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”–ыг Хороо батлан мөрдүүлж байна.

Журамд даатгалын үйл ажиллагаа эрхлэгчид ипотекийн даатгалын бүтээгдэхүүнээ боловсруулан Санхүүгийн зохицуулах хороогоор хянуулж, бүртгүүлэхээр заасны дагуу 2019 оны 4 дүгээр сарын байдлаар “МИГ даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК, “Ард даатгал” ХК, “Практикал даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Мандал даатгал” ХК, “Бодь даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, Гэр даатгал ХХК, “Соёмбо даатгал” ХХК, “Нейшнл лайф даатгал” ХХК гэсэн арван хоёр компани бүтээгдэхүүнээ хянуулж, бүртгүүлээд байна.

Ипотекийн даатгалын бүтээгдэхүүнүүд бий болсонтой холбогдуулан зээлдэгч–даатгуулагчдад дараах зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна.

1. ДААТГУУЛАГЧ ТА ДААТГАЛЫН КОМПАНИ НЬ ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД БҮРТГҮҮЛСЭН ЭСЭХ ТАЛААР БОЛОН ДААТГАГЧ, ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ–БАНКАА САЙТАР СУДЛАХ.

- Ипотекийн даатгал нь “Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал”, “Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал” гэсэн 2 төрлийн даатгалын бүтээгдэхүүн буюу даатгалын гэрээнээс бүрдэнэ;
- Даатгалын компани нь “Ипотекийн даатгал”–д хамаарах бүтээгдэхүүнүүдээ Хороонд бүртгүүлсэн тохиолдолд зах зээлд борлуулж, иргэд, даатгуулагчийг даатгалд хамруулна;
- Даатгалын компанийг эрхлэх даатгалын ангиллаас хамаарч ердийн ба урт хугацааны даатгагч гэж ангилах бөгөөд ердийн даатгалын компаниуд нь “Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал”, “Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”–ыг зах зээлд борлуулах эрхтэй бол урт хугацааны даатгалын компани зөвхөн “Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”–ын бүтээгдэхүүнийг борлуулна;
- Ипотекийн зээл олгодог дийлэнх банк/9/ нь тус Хорооноос даатгалын

зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, даатгалын гэрээ борлуулсны хөлсөнд ажиллагааны зардал болох тодорхой хэмжээний шимтгэл авч ажилладаг тул танд даатгалын гэрээний талаар зөвлөмж өгөх болон даатгалын зуучлагчийн бусад үүргийг хүлээж ажиллана;

- “Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”–ын бүтээгдэхүүний хувьд ердийн даатгалын компани нь зөвхөн гэнэтийн ослын улмаас нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах тохиолдлыг даатгах бол урт хугацааны даатгалын компани аливаа шалтгаанаар буюу гэнэтийн ослын болон өвчний улмаас нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс хувь алдах тохиолдлыг даатгадаг;
 - Даатгуулагч нь аль ч даатгалын компанид даатгуулах эрхтэй буюу даатгалын гэрээгээр хамгаалах эрсдэл, даатгалын хураамжийн хувь, даатгалын нөхөн төлбөр олгохгүй байх нөхцөл зэргээс хамаарч даатгагчаа сонгох, банк нь даатгуулагчийг энэхүү сонголт хийх боломжоор хангах үүрэгтэй.
- ### 2. ДААТГАГЧ БҮРИЙН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН БҮЮУ ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛҮҮДИЙГ САЙТАР СУДАЛЖ, ХАРЬЦУУЛАЛТ ХИЙЖ ҮЗЭХ.
- Даатгалын компани нь худалдан борлуулах даатгалын гэрээгээ судалж боловсруулдаг тул компани бүрийн даатгалын гэрээний хамгаалалт, нөхцөл шаардлага ялгаатай болохыг анхаарах;
 - Даатгалын гэрээн дэх хасалтын нөхцөлүүд болон даатгалаар хамгаалах нөхцөл, даатгалын тохиолдол үүсэхэд бүрдүүлэх баримт бичиг зэргийг сайтар уншиж танилцан, харьцуулах, даатгалын компанийн эсхүл зуучлагчийн ажилтнаас тодруулан асуух, зөвлөгөө авах;
 - Даатгалын компани бүрийн даатгалын хураамжийн хэмжээ нь тухайн компанийн даатгалын гэрээний хамгаалалт, хүлээх эрсдэл, нөхөн төлбөр олгохгүй нөхцөл зэргээс хамаарч харилцан адилгүй байх хэдий ч Хороонд бүртгүүлсэн даатгалын хураамжийн хувиас хэтрэх буюу илүү хураамжийг даатгуулагчаас шаардах боломжгүйг анхаарах.

- Урьдчилгаа зээлд барьцаалсан орон сууцыг даатгуулах эсэхээ даатгуулагч өөрөө шийдэх тул шинээр худалдан авсан бөгөөд зээлийн барьцаанд барьцаалуулсан орон сууцыг зөвхөн барьцаа хөрөнгийн даатгалд хамруулах боломжтойг анхаарах;
- Зарим ердийн даатгалын компани нас баралтын томоохон шалтгаанууд болох цус харвалт, зүрх гэнэт зогсох/хаагдах эрсдэлүүдийг нэмэлт эрсдэлээр даатгах саналыг иргэд, даатгуулагчдад гаргах боломжтой тул сонголтоо хийх;
- Барьцаа хөрөнгийг түрээслүүлэх үед даатгалаар хамгаалах эсэхийг даатгалын нөхцөлөөс сайтар судлах;
- Даатгалын гэрээний үүргээ биелүүлээгүй

буюу 72 цагийн дотор даатгагчид даатгалын тохиолдлын талаар мэдэгдээгүй бол даатгалын нөхөн төлбөр олгох эсэхийг гэрээний нөхцөлөөс сайтар харж, анхааралдаа авах;

- Жирэмслэлтээс үүдсэн даатгалын тохиолдолд даатгалын нөхөн төлбөр олгох эсэхийг сайтар судлах;
- Монгол Улсаас бусад улсад таны даатгал үйлчлэх эсэхийг сайтар судлах;
- Даатгагч зээлийн хүүгийн төлбөрийг төлөх эсэхийг даатгалын гэрээний нөхцөлөөс сайтар судлах;
- Даатгуулагчийн банкнаас авсан нийт зээлийн хэмжээнд үндсэн ба хамтран зээлдэгчийн эзлэх хувь нь даатгалын компаниас даатгуулагчид олгох нөхөн

төлбөрийн хэмжээг тодорхойлоход чухал нөлөөтэй тул тус хувийг өөрчлүүлэх саналыг даатгуулагчийн зүгээс даатгагч болон зээл олгосон банкинд хандаж гаргах боломжтой эсэх;

- Даатгуулагч аваар ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар түр алдсан эсхүл бүр алдсан аль ч тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг олгох эсэх;
- Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалаар даатгалын хохирол үнэлгээний зардлыг хэн төлөх талаар тодруулах;
- Даатгуулагч буруутай бол даатгалын нөхөн төлбөрөөс хасагдах эсэхийг тус тус судалж үзэх.

ТЕХНОЛОГИЙН БУЛАН / Insurtech гэж юу вэ?

Insurtech бол финтекийн нэг төрөл бөгөөд шинэ технологиудыг даатгалын салбарт ашигладаг.

Зураг 1. InsurTech хөрөнгө оруулалтын хандлага (2012–2018)




Уламжлалт даатгалын компаниуд өдрөөс өдөрт нэмэгдэж буй даатгалын технологийн стартапуудын өрсөлдөөнтэй нүүр тулж байна. Олон шинжээчид тус салбарыг шинэ технологийн хэрэгцээ хамгийн ихтэй байгаа гэж үзэж байна.

"Insurtech" гэдэг нь шинэ технологиудыг даатгалын салбарт нэвтрүүлэх шинэлэг

санаачлагыг бий болгох, даатгалын зах зээлийн зохицуулалтын үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой нэр томъёо юм.

Шинэ технологийг нэвтрүүлэх нь санхүүгийн салбарын өөрчлөлтийн гол хөдөлгөгч хүч бөгөөд энэ нь хэрэгжүүлж эхлэхэд эргэлзээтэй байх хэдий ч хэмжигдэхүйц үр ашгийг бий болгодог.



Эх сурвалж : CB Insights (2019a) Даатгалын Техникийн Шинжилгээ

“Sandbox” арга нь СМЗГ–ын тогтоосон хууль эрхзүйн болон зохицуулалтын шаардлагыг зөөлрүүлэхэд FinTech шийдлүүдийн хувьд СМЗГ–ын дэмжлэгийг дараах тохиолдлуудад авах боломжгүй юм:

- Сингапурт аль хэдий санал болгосон технологитой адил бол дэмжлэг авах боломжгүй. Гэхдээ өргөдөл гаргагч нь өөр технологи ашиглаж байгаа эсвэл ижил технологийг өөрөөр ашиглаж байгаа гэдгээ баталж чадвал дэмжлэг авч болно.

- Өргөдөл гаргагч нь санал болгож буй санхүүгийн үйлчилгээг лабораторийн орчинд туршсан, мөн санал болгож буй санхүүгийн үйлчилгээг хэрэглэх хууль эрх зүйн шаардлагыг хангаж байгааг харуулаагүй бол дэмжлэг авахгүй.

Мөн түүнчлэн “sandbox” орчноос гарсны дараа FinTech шийдлийг Сингапурт хэрэглэх зорилготой байх ёстой.

СМЗГ нь хамгаалалтанд өргөдөл гаргагчид цаашид хэрэгжүүлж байх ёстой шаардлагуудыг тодорхойлноос

гадна зөөлрүүлсэн шаардлагуудыг ч мөн адил тавьдаг. Харин тавигдаж буй хатуу шаардлагуудад хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, үнэнч шударга байдал, зуучлагчаар дамжиж байгаа харилцагчдын мөнгө, эд хөрөнгөтэй харьцаж байгаа байдал, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс хэрхэн сэргийлж байгаа зэрэг шаардлагууд орно.

Эх сурвалж : СМЗГ, FinTech Зохицуулалтын Хамгаалалтын удирдамж.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧДИЙН НҮДЭЭР

“Effisoft” компанийн удирдах захирал
Julien Victor


Хиймэл оюун ухаан, блокчейн, бизнесийн оюун ухаан, үүлэн систем, их өгөгдлийн тусламжтайгаар байнгын шинэчлэлт хийсний үр дүнд даатгалын салбар нь бүхэлдээ өөрчлөгдөж байна. 2019 оны томоохон сорилт нь зардлыг хянан, технологийн хязгаарлалуудыг даван туулахын зэрэгцээ автоматжуулах үйл явц юм. Давхар даатгалын үйл ажиллагааг автоматжуулах нь бас нэгэн сайн жишээ юм. Даатгагчид гэрээний төвлөрөл, нөхөн төлбөрийн хяналт, нууцлал болон мэдээллийн аюулгүй байдлын сайжруулалт, зохицуулалтын комплаенсыг хялбаршуулан сайжруулахыг зорьж байна.

“Paychex” компаний даатгалын үйлчилгээний дэд ерөнхийлөгч
Sally Prather

Технологи, дижиталчлал, өгөгдлийн ил тод байдал зэргүүдийг нэмэгдүүлснээр жижиг бизнес эрхлэгчид болон дунд хэмжээний ажил олгогчид өөрсдийн бизнес, ажилчдын хүртээмж, хурдыг өөрчлөх арга замуудыг хайж байна. Жишээлбэл, ажил олгогчид шинэ ажилтан авахаас эхлүүлээд үүлэн системээр өөрсдийн ажиллах хүчийг удирдах боломжийг олгодог шинэ хэрэгслүүд гарсан байна. Энэ хэрэгслүүдийн тусламжтайгаар ажил олгогчдын захиргааны ажлын ачааллыг бууруулж ажиллагсдад өөрсдийн мэдээллийг удирдах боломжийг олгодог.

Corvos Insurance – компаний үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал
Phil Edmundson

Гурван жилийн өмнө арилжааны даатгал нь зах зээлийн үр ашгийг дээшлүүлэх, үйлчилгээг сайжруулахад анхаарч, гар утасны камерыг ашиглан тээврийн хэрэгслийн болон эд хөрөнгийн даатгалын нэхэмжлэлийг шийдвэрлэх хурдыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байв. Хоёр дахь том давалгаа нь даатгалын технологийн компаниуд цахим худалдааны брокероор дамжуулан 7 хоногийн 24 цагаар дижитал маркетинг бүхий арилжааны даатгалын борлуулалт хийхэд анхаарлаа төвлөрүүлж, шинэ бүтээгдэхүүн гаргаж эхэлсэн. Арилжааны даатгалын гурав дахь том давалгаа нь компаниуд гар утас, олон нийтийн сүлжээ, юмсын интернет, их өгөгдөл зэрэг шинэ арга хэлбэрийг ашиглан нөхөн төлбөрийн таамаглалыг илүү сайжруулаад зогсохгүй байгууллагуудад муу зүйлс тохиолдохоос урьдчилан сэргийлэхэд тусалж байна. Даатгалын эдгээр өөрчлөлтүүд нь ирэх гурван жилд өгөгдөл, түүний хэрэглэгдэх боломжийг илүү нэмэгдүүлэх болно.



INTERNATIONAL ASSOCIATION OF
INSURANCE SUPERVISORS

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

ДААТГАЛЫН ХЯНАН
ШАЛГАГЧДЫН ОЛОН
УЛСЫН ХОЛБООДААТГАЛЫН ХЯНАН ШАЛГАГЧДЫН ОЛОН
УЛСЫН ХОЛБООНЫ ҮҮСЭЛ

Тус холбооны үүсэл анх 1980–аад оноос National Association of Insurance Commissioners (NAIC) буюу Даатгалын зохицуулагчдын үндэсний холбооны жил бүрийн уулзалтад олон улсын даатгалын зохицуулагч нар оролцож эхэлснээс эхлэлтэй гэж хэлж болно. Даатгалын салбар бол банк болон үнэт цаасны салбартай адил улс орны эдийн засаг, нийгмийн чухал ач холбогдол бүхий гол тулгуур салбарын нэг бөгөөд энэхүү салбарын олон улс дахь даатгалын зохицуулагч нарын уулзаж, мэдлэг туршлага солилцох боломжийг зөвхөн Даатгалын зохицуулагчдын үндэсний холбооны жил бүрийн уулзалтаар олгож байсан юм. Иймд даатгалын салбарын цаашдын хөгжлийг дэмжих, тогтвортой байдлыг хангах, хяналт зохицуулалтыг тогтвортой үр ашигтай байлгах зорилгоор энэхүү хурал, уулзалтыг илүү албан ёсны болгож, олон улсын хянан шалгагч нарыг бүрэн хамруулсан байгууллагыг бий болгох шаардлагатай гэж үзсэн.

Улмаар 1992 оны 6 дугаар сард зохион байгуулсан NAIC–ийн олон улсын VII уулзалтаар “Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо”–г байгуулахаар шийдвэрлэсэн байна. Холбоог байгуулахтай холбоотойгоор байгууллагын дотоод дүрэм, журмыг боловсруулах болон бусад бэлтгэл ажлыг хангах ажлуудыг хийж гүйцэтгэсний үр дүнд тус холбоог 1994 оны 3 дугаар сард АНУ–ын Illinois мужийн Springfield хотод 68 гишүүнтэйгээр албан ёсоор үүсгэн байгуулж, тухайн оны 6 дугаар сард АНУ–ын Maryland мужийн Baltimore хотод холбооны анхны уулзалтыг зохион байгуулсан байдаг.

International Association of Insurance Supervisors (IAIS) буюу Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо нь даатгалын салбарын зохицуулагч, хянан шалгагч нарын үүсгэн байгуулсан тус салбарт мөрдөгдөх стандартыг тогтоох чиг үүрэг бүхий ашгийн бус, сайн дурын гишүүнчлэл бүхий олон улсын байгууллага юм. Тус холбоо нь даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, даатгалын салбарыг зүй зохистой хөгжүүлэх, тухайн салбарын хяналт зохицуулалтыг тогтвортой, үр ашигтай байлгах зорилготой бөгөөд энэхүү зорилгын хүрээнд даатгалын салбарт мөрдөгдөх зарчим, стандарт, зөвлөмжийг батлан, тэдгээрийг мөрдүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Харин 1996 оны 10 дугаар сард олон улсад тус холбоог даатгалын салбар дахь стандарт тогтоогч байгууллагаар хүлээн зөвшөөрсөн бөгөөд тус холбооноос 1999 оны 12 дугаар сард даатгалын салбарт мөрдөгдөх үндсэн зарчмуудыг анх баталсан. Энэхүү зарчмуудад 2003 болон 2011 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, өнөөдрийн байдлаар даатгалын салбарт “Даатгалын 26 тулгуур зарчим”–ыг (Insurance Core Principles)–ыг мөрдөж байна.

ДААТГАЛЫН ХЯНАН ШАЛГАГЧДЫН ОЛОН
УЛСЫН ХОЛБООНЫ ЧИГ ҮҮРЭГ

Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбооноос үйл ажиллагаа явуулахдаа зөвхөн цөөн хэдэн сэдвээр хязгаарлагдахгүйгээр, даатгалын зах зээл дэх аудит, нягтлан бодох бүртгэл, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, цаг уурын өөрчлөлттэй холбоотой үүсэх эрсдэл, хөгжиж буй зах зээл, санхүүгийн хүртээмжтэй байдал, санхүүгийн тогтвортой байдал, Финтек, компанийн засаглал, давхар даатгал, зохицуулагч нарыг чадавхжуулах, системийн эрсдэл зэрэг өргөн хүрээний сэдвийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг. Үүний дотроос даатгалын салбарт мөрдөгдөх стандартыг тогтоох нь тус байгууллагын үндсэн чиг үүргийн нэг юм. Энэхүү ажил үүргийн хүрээнд даатгалын салбарт тогтвортой, үр ашигтай хяналт зохицуулалтыг бий болгох зорилгоор тус холбооноос Insurance Core Principles (ICP) буюу “Даатгалын тулгуур зарчим”–ыг баталсан.

Энэхүү даатгалын тулгуур зарчмууд нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, даатгалын хяналт шалгалтад тавигдах шаардлагууд бөгөөд даатгалын салбарын зохицуулалтад

тусгах шаардлагатай бүхий л асуудлуудыг хамарч чадсан байдаг. Даатгалын тулгуур зарчмууд нь даатгалын хяналт шалгалтад тавигдах хамгийн чухал шаардлагыг тодорхойлсон ЗАРЧМУУД, тухайн зарчимтай холбоотойгоор мөрдөх СТАНДАРТУУД, тэдгээр нь юуг илэрхийлж байгаа, хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарласан ЗӨВЛӨМЖҮҮДЭЭС бүрддэг. “Даатгалын тулгуур зарчим”–д дараах 26 зарчим багтаж байна. Үүнд:

- ICP 1.** Зохицуулагчийн зорилго, эрх мэдэл болон хариуцлага;
- ICP 2.** Зохицуулагч байгууллага;
- ICP 3.** Мэдээлэл солилцоо, нууцлалд тавигдах шаардлага;
- ICP 4.** Зөвшөөрөл олголт;
- ICP 5.** Тохиромжтой этгээд;
- ICP 6.** Удирдлагын багцын өөрчлөлт, шилжилт;
- ICP 7.** Компанийн засаглал;
- ICP 8.** Эрсдэлийн удирдлага болон дотоод хяналт;
- ICP 9.** Зохицуулагчийн хяналт, тайлагнал;
- ICP 10.** Урьдчилан сэргийлэх болон засч залруулах арга хэмжээ;
- ICP 11.** Албадлагын арга хэмжээ;
- ICP 12.** Компанийг татан буулгах болон зах зээлээс гаргах;
- ICP 13.** Давхар даатгал болон эрсдэлийг шилжүүлэх бусад арга замууд;
- ICP 14.** Үнэлгээ;
- ICP 15.** Хөрөнгө оруулалт;
- ICP 16.** Байгууллагын эрсдэлийн удирдлага ба төлбөрийн чадвар;

- ICP 17.** Хөрөнгийн хүрэлцээтэй байдал;
- ICP 18.** Зуучлагчид;
- ICP 19.** Бизнесийн ёс зүй;
- ICP 20.** Олон нийтэд мэдэгдэх;
- ICP 21.** Даатгалын залилантай тэмцэх талаар;
- ICP 22.** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар;
- ICP 23.** Группийн хяналт зохицуулалт;
- ICP 24.** Макро орчны системийн хэмжээний хяналт ба даатгалын зохицуулалт;
- ICP 25.** Зохицуулагчийн хамтын ажиллагаа ба уялдаа холбоо;
- ICP 26.** Онцгой байдлын удирдлага ба хил дамнансан хамтын ажиллагаа, уялдаа холбоо.

Даатгалын салбарын зохицуулагч байгууллагууд дээрх зарчмуудыг өөрийн салбарт мөрдөгдөж буй хууль, дүрэм,

журамд тусган ажилладаг бөгөөд олон улсад тухайн орны даатгалын салбарын хяналт зохицуулалтын түвшинг дүгнэхдээ дээрх зарчмуудыг хэрхэн мөрдөн ажиллаж байгаа болон хэрхэн дүрэм журамдаа тусгасан байгаагаар дүгнэж байна.

IAIS ӨНӨӨДӨР

Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо нь өнөөдрийн байдлаар 150 гаруй орны 213 даатгалын зохицуулагч байгууллагуудыг өөрийн гишүүнчлэлд нэгтгэсэн байгаа бөгөөд гишүүд нь ихэвчлэн улс орон болгоны даатгалын салбарыг зохицуулах, хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд болон Төв банк, Сангийн яам зэрэг байгууллагууд байдаг. Гишүүн байгууллагын зохицуулалтад дэлхийн нийт даатгалын зах зээлийн 97 хувь хамрагдаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2007.09.19-ний өдөр тус байгууллагад гишүүнээр элссэн

ба тус байгууллагаас баталсан “Даатгалын тулгуур зарчим”-уудыг холбогдох хууль, дүрэм, журамд тусган ажиллаж байна. Тухайлбал, тус холбоо даатгалын салбарын мэргэжилтнүүдийг хамруулсан чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд энэхүү уулзалтаар даатгалын салбарт нөлөөлж буй олон талт хүчин зүйлс, тэдгээрийн нөлөөлөл болон зохицуулагч байгууллагууд тэрхүү өөрчлөлт, нөлөөнд хэрхэн ажиллах, зохицуулах талаар өргөн хүрээний сэдвийг хөнддөг. Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл энэхүү уулзалтад идэвхтэй оролцож, дэлхийн бусад орны даатгалын зохицуулагч байгууллагуудтай мэдлэг, туршлага солилцон, олон улс дахь зохицуулалтын сайн туршлагыг Монгол Улсын даатгалын зах зээлд нэвтрүүлэн ажиллаж ирсэн.

2019 онд тус холбоо үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ой тохиож байна.

ӨРГӨН ДУРАН

Санхүүгийн зохицуулах хороо нь даатгалын үйл ажиллагааг хүртэх боломжгүй бага болон дунд орлоготой иргэдэд даатгалын үйлчилгээг хүргэх зорилгоор 2013 оны 5 дугаар сард MEFIN тунхаг бичигт гарын үсэг зурж, Азийн 7 орныг багтаасан MEFIN сүлжээнд нэгдэн орсон. Уг тунхаг бичгийн дагуу ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” хөтөлбөрт оролцож, хөтөлбөрийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо хүртээмжтэй даатгалын тодорхойлолт, түүнд тавигдах шаардлагыг бий болгож, MEFIN сүлжээний хэд хэдэн удаагийн Олон улсын арга хэмжээг Монгол Улсдаа зохион байгуулаад байгаа.

Хөтөлбөрийн хүрээнд олон улсын судалгаа, зөвлөгөө, бодлогын зөвлөгөө, төслийн менежер болон хяналт үнэлгээний чиглэлээр мэргэшсэн олон улсын зөвлөх, хатагтай Магдалена Сегре хүртээмжтэй даатгалын салбар дахь санхүүгийн боловсролын түвшинд үнэлгээг хийж ажилласан.

Ингээд түүнтэй хийсэн ярилцлагыг хүргэе.

Монгол Улсад санхүүгийн хүртээмжийн талаарх ойлголтын түвшин ямар байна вэ? Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд бид ямар арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж та бодож байна?

Санхүүгийн хүртээмж гэдэг нь иргэд, бизнес эрхлэгчид санхүүгийн үйлчилгээг хүртэх боломж юм. Монголын нийт хүн амын 93,8 хувь нь банкинд данс эзэмшдэг гэсэн тоон мэдээлэл бий хэдий ч хадгаламж, даатгал гэх мэт бусад санхүүгийн бүтээгдэхүүний талаарх мэдлэгийн дутмаг байдал нь сул тал хэвээр байна. Санхүүгийн зохицуулах хорооноос банкнаас бусад санхүүгийн салбарын “Санхүүгийн хүртээмжийн үндэсний стратеги”-ийг боловсруулахаар ажиллаж байгаа нь Монгол Улсад санхүүгийн хүртээмжийг сайжруулахад үүсч буй саад, бэрхшээлийг шийдвэрлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Иргэд, бизнес эрхлэгчдийн хувьд санхүүгийн боловсрол болоод санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдлэгийн хангалтгүй байдал,

мөн санхүүгийн салбарт итгэх итгэл сул байгаа нь санхүүгийн хүртээмжийн өсөлтөд сөргөөр



нөлөөлж байна. Боловсрол, тэр дундаа санхүүгийн боловсрол зайлшгүй шаардлагатай. Санхүүгийн суурь мэдлэг, боловсрол нь хэрэглэгч төрөл бүрийн санхүүгийн шийдвэр гаргахад нь туслах хүчтэй зэвсэг болох тул санхүүгийн суурь мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх талаар тусгасан санхүүгийн хүртээмжийн талаар иж бүрэн стратегийг бий болгох нь зайлшгүй чухал юм. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд санхүүгийн суурь мэдлэг нь санхүүгийн байгууллагад олон нийтийн



даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхийн тул хууль, эрх зүйн орчин ямар байх нь илүү зохимжтой гэж та үзэж байна?

Иргэдийн дунд даатгалын суурь мэдлэг, ойлголтыг бий болгох асуудал нь даатгалын салбарын оролцогчидтой хамтран олон нийтийн санал асуулга явуулахаас эхлээд стратегийг боловсруулах, иргэдэд санхүүгийн боловсролыг олгох тусгайлсан үйл ажиллагаа, компани ажил хэрэгжүүлэх, түүний үр дүнг үнэлэх гээд их өргөн хүрээг хамарна. Энэ ч утгаараа компани ажилд тоглоом, кино, ном, танилцуулах хуудас, үзүүлэн самбар, сургалт, радиогийн хөтөлбөр, шог хөтөлбөр болон жүжигчилсэн тоглолт гэх мэт маш олон аргыг ашиглаж болно.

Олон Улсын туршлагаас харахад хүртээмжтэй даатгалд хэд хэдэн бэрхшээлүүд тулгарч байдаг. Үүнд: Даатгалын нөхцөлийг энгийн ойлгомжтой байдлаар тодорхойлох, нөлөө үзүүлэхүйц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц бололцоо, тэгээд хувийн секторын үр нөлөө бүхий оролцоо. Нөгөө талаасаа, даатгалын салбар дахь оролцогчдын сайн удирдлага, зохион байгуулалт, компани ажлын маш ухаалаг загвар, түүний сонголт, өндөр чанартай арга хэрэгсэл, материалын хэрэглээ, мөн нөлөө бүхий зах зээлийн оролцогчид болон сургагч багшийн сургалтад ач холбогдол өгөх байдал зэрэг нь компани ажлыг үр дүнтэй явуулах үндэс юм.

Өмнөх туршлагаудаасаа харахад зах зээлд оролцогчдын нягт холбоо, харилцаа, тэдгээрийн хүчин чармайлт, инновацийг агуулсан зардал хэмнэхүйц арга хэрэгслийг сонгох болон даатгалын боловсролд нөлөөлөх туршлагыг бий болгосон байх нь хамгийн чухал байна.

Монгол Улс бага, дунд орлоготой иргэдэд даатгалыг хүргэх, түгээх буюу хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц байх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал бөгөөд хүртээмжтэй даатгалын сурталчилгаа хийхэд ашиглахад тохиромжтой тоон болон чанарын үзүүлэлт бүхий тодорхойлолттой байх, түүнчлэн даатгалын хураамжийг актуар тооцоололд үндэслэн байгуулдаг байх шаардлагатай. Мөн хүртээмжтэй даатгалыг түгээх борлуулалтын сувгийг өргөжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тохиромжтой тогтолцоог бүрдүүлэх нь нэн чухал асуудал юм.

итгэх итгэлийг бий болгодог ба ингэснээр санхүүгийн систем дэх хадгаламж болон урт хугацаат санхүүгийн хөрөнгө оруулалтыг дэмждэг.

Даатгалын зах зээлд оролцогчид, даатгалын компаниуд болон зохицуулагч байгууллагын зүгээс санхүүгийн суурь мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ямар арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой вэ? Энэ хүрээнд MEFIN ямар гол үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байгаа талаар бидэнтэй хуваалцаач?

Даатгалын зорилго, үүрэг болон үр ашиг, бүр цаашлаад даатгуулагчийн эрх үүрэг, мөн тэдний эрх ашгийг хамгаалах тогтолцооны талаар мэдээлэл өгөх зорилго бүхий компани ажил зохион байгуулах нь их үр дүнтэй арга байдаг. Энэ нь Монголын хүн амын дунд даатгалын соёлыг бий болгох гол хөшүүрэг болох төдийгүй бага орлоготой иргэд болон албан бус бизнесийн салбарт ажиллагсдыг өөрийн хөрөнгөө хамгаалах, өөрт буй нөөц, бололцоогоо үр дүнтэй удирдахад нь туслахад ихээхэн хувь нэмрээ оруулах болно. Ийм үйл ажиллагааны гол зорилго нь иргэдийг даатгалын бүтээгдэхүүний талаар маш сайн ойлголттой болгох, даатгалын хэрэглээг бий болгох чиглэлээр хэрэглэгчийн зан төлөв, хандлагыг өөрчлөх, мөн түүнчлэн даатгалын талаарх иргэдийн буруу, ташаа ойлголтыг засаж, залруулах юм. Монгол Улс бусад улсуудын нэн ялангуяа Азийн орнуудын сайн жишээнээс үлгэр дууриалал авч болно шүү дээ. Филиппин ийм хэлбэрийн компани

ажлыг амжилттай зохион байгуулсан туршлагатай. Энэхүү компани ажил нь сурталчилгаа, худалдаа хийхээс илүүтэй боловсрол олгох, ухуулах, ойлгуулахад чиглэсэн төдийгүй хотоос алслагдсан бүс нутаг болон албан бус салбарт ажилладаг бага орлоготой иргэдэд илүүтэй чиглэж олон нийтийг хамарсан мэдээллийн суваг /хэвлэмэл материал, радио, зурагт, цахим хуудас/ болон харилцаа холбооны хэрэгсэл /гар утас/ гээд маш олон төрлийн сувгаар мэдээллийг хүргэж ажиллахаас гадна эдгээр сувгаас иргэдэд хамгийн их хүрч байгаа мэдээллийг турших, болон түүний нөлөөллийг үнэлж ажилласан. Энэхүү аргыг Монголын онцлогт тохируулан ашиглавал их үр ашигтай байх болно. Хамгийн гол нь уг үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх гээд бүхий л үйл ажиллагаанд даатгалын салбар дахь бүх оролцогчид оролцох нь чухал юм.

Филиппиний энэхүү туршлагад суурилан MEFIN-ий улсуудын зохицуулалтын байгууллагууд өөрийн улсын даатгалын салбарын оролцогчидтой хамтран хүртээмжтэй даатгалын талаарх иргэдийн боловсролыг сайжруулах компани ажлыг амжилттай зохион байгуулж ажиллаж эхлээд байгаа. Монголын хувьд ч мөн олон улсын сайн туршлага, ололт амжилтыг өөрийн улсын онцлогт тохируулан өөрчлөн ашиглах боломжтой.

Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх Олон Улсын туршлагын талаар дурдвал? Манай улсад бага, дунд орлоготой иргэдийн

ХЭРЭГЛЭГЧ

ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ОЛОН НИЙТЭД ХЭРХЭН ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭХ ВЭ?

Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.6-д “Хүртээмжтэй даатгал” гэдгийг “Олон нийтийн хэрэгцээ, худалдан авах чадварт нийцсэн, даатгалын үндсэн зарчмыг агуулсан, энгийн хялбар сайн дурын даатгалын бүтээгдэхүүн” гэж тодорхойлсон бөгөөд Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэхэд Хороо дараах шаардлагыг тавьж ажиллаж байна:

- Даатгалын гэрээний үг хэллэг нь энгийн, ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, даатгуулагчийг төөрөгдүүлэхээргүй байх;

- Даатгалын үнэлгээ, хураамжийн дүн харьцангуй бага байх;
- Даатгалын гэрээнд тусгасан даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийн тоо нь 5-аас хэтрэхгүй бөгөөд даатгуулагчид ойлгомжтой байх;
- Даатгалын тохиолдол болсон нь холбогдох баримтаар нотлогдсон нөхцөлд даатгуулагчид чирэгдэл учруулалгүйгээр даатгалын нөхөн төлбөрийг 10 хоногийн дотор олгодог байх.

Даатгагч Хороонд бүртгүүлсэн хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүний даатгалын гэрээ, даатгалын үнэлгээ, даатгалын хураамжид аливаа өөрчлөлт оруулсан нөхцөлд дахин шинээр бүртгүүлэх үүрэгтэй.

Хороонд бүртгүүлсэн хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл:

№	Даатгалын компани	№	Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн
1	"Монре даатгал"ХХК	1	Гэр хашаа байшингийн даатгал
	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	2	Гэр хашаа байшингийн даатгал
2		3	Өрхийн гэнэтийн ослын даатгал
		4	Хүүхдийн гэнэтийн ослын даатгал
		5	Нийтийн ба хувийн орон сууцны хүртээмжтэй даатгал
		6	Орон сууцны хариуцлагын хүртээмжтэй даатгал
3	"Хаан даатгал" ХХК	7	"Орон сууцны иж бүрэн даатгал"
4	"Монгол даатгал" ХХК	8	Иргэдийн гэнэтийн ослын хүртээмжтэй даатгал
5	"Нэйшнл лайф даатгал" ХХК	9	Гэр хашаа байшингийн хүртээмжтэй даатгал
		10	Хорт хавдрын даатгал



ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

"АЗИЙН ОРНУУДАД ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО" /MEFIN/ ХӨТӨЛБӨРИЙН БҮС НУТГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГААР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА С.ДАВААСҮРЭН АЖИЛЛАЖ БАЙНА



Implemented by
giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Mutual Exchange Forum
on Inclusive Insurance

ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ -ээс 2013 оноос хэрэгжүүлж буй тус хөтөлбөр нь даатгалын үйл ажиллагааг хүртэх боломжгүй бага болон дунд орлоготой иргэдэд даатгалын үйлчилгээг хүргэх зорилготой бөгөөд анх байгуулагдахдаа

Монгол, Индонез, Вьетнам, Пакистан, Филиппин болон Балбын Вант улсыг хамарч байсан бол 2017 оноос Шри-ланк улс элсэн орсон. Санхүүгийн зохицуулах хороо нь 2013 оноос уг хөтөлбөрийн гишүүн болсон.



Бүс нутгийн ядуурлыг бууруулах чиглэлд хүртээмжтэй даатгалыг дэмжих стратегитай ажиллаж буй Азийн улс орны зохицуулалтын байгууллагууд болон хувийн секторыг нэг дор цуглуулж, хамтдаа хэлэлцэх боломж олгодгоороо уг хөтөлбөрийн давуу тал бөгөөд эхний шат нь 2015 оны 12 дугаар сар хүртэл, 2 дахь шат нь 2016 оны 1 дүгээр сараас 2018 оны 12 дугаар сар хүртэл тус тус 3 жилээр

хэрэгжсэн бөгөөд одоо 3 дахь шат нь 2019 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжиж эхлээд байна.

Хөтөлбөр нь гишүүдийнхээ дунд мэдлэг, туршлага солилцох үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Хүртээмжтэй даатгалын туршлага солилцох форум" (Mutual Exchange Forum on Inclusive Insurance-MEFIN)-ыг байгуулан ажиллаж байна.

MEFIN-ийн зохион байгуулалтын бүтцийг дор харуулав:



MEFIN-ийн сүлжээ нь олон улсын хэмжээнд түгээмэл ашиглагдаж буй peer to peer exchange ийг ашиглаж байгуулсан хамгийн бодит жишээ бөгөөд бид энэхүү сүлжээнд нэгдэн орсноор хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх чиглэлээр зохицуулагчийн болон зах зээлд оролцогч хувийн секторуудад тулгарч буй бэхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг бусад улс орнуудын төлөөлөлтэй хэлэлцсэний үр дүнд олж авах, түүнийг өөрийн оронд ашиглах боломжийг бүрдүүлсэн юм.

MEFIN-ийн Бүс Нутгийн Удирдах Зөвлөлийн Хороо (БНУЗХ) нь хөтөлбөрт оролцогч улсуудын зохицуулалтын байгууллага болон хувийн хэвшлийнхнийг оролцуулсан дараах үндсэн 5 ажлын хэсэгт санал, зөвлөгөө өгч ажилладаг.

Бодлого ба зохицуулалтын ажлын хэсэг /TWG on Regulation and supervision/: Даатгалын үндсэн зарчим (ICP)-д тулгуурлан Хүртээмжтэй даатгалд тавигдах шаардлага, бизнесийн загвар, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, хамгаалах, болон хяналт шалгалтын практиктэй холбогдох материалыг бий болгох. Ингэхдээ байгалийн гамшиг, хөдөө аж ахуйн салбар, жижиг дунд үйлдвэрлэл болон эрүүл мэндийн салбарт илүүтэй анхаарах;

Бизнесийн загварын ажлын хэсэг /TWG on Business model/: Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үнэ бүрдүүлэлт, бүтээгдэхүүний багц, актуарын тооцоолол, боломжит борлуулалтын суваг болон нөхөн төлбөрийн удирдлагатай холбоотой практик тохиолдлуудыг нэгтгэсэн материалыг бий болгох;

Мэдлэгийн удирдлагын ажлын хэсэг /TWG on Knowledge management/: Хөтөлбөрт оролцогч гишүүдийн хооронд мэдээлэл

солилцох платформ болон арга хэрэгслүүдийг судалж, хэрэглэх, ашиглах зааварчилгаа гаргах;

Чадавх бүрдүүлэлтийн ажлын хэсэг /TWG on Capacity building/: Зохицуулалтын байгууллага дотроо Хүртээмжтэй даатгалын хэлтэс, алба, техникийн хороо, ажлын хэсгийг удирдах арга барилыг тодорхойлох зааварчилгааны материалыг бий болгох;

Гамшгийн эрсдэлийн даатгалын ажлын хэсэг /TWG on Disaster risk insurance/: MEFIN-ий сүлжээн дэх улсууд хоорондоо Гамшгийн эрсдэлийн даатгалын бодлого, эрх зүйн орчин дахь өөрчлөлтийн талаарх мэдээллийг хоорондоо солилцох, эдгээр өөрчлөлтийн даатгалын зах зээлд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, үүндээ тулгуурлан гамшгийн эрсдэлийн даатгалын шинэ санаа, санаачлага, загварыг санал болгох.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга С. Даваасүрэн тус хөтөлбөрийн Бүс нутгийн удирдах зөвлөлийн даргаар ажилладаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо нь бодлого ба зохицуулалт, бизнесийн загварын ажлын хэсэгт тус тус ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байна.

RFPI Asia хөтөлбөр нь эхний үе шатанд Азийн бага, дунд орлоготой иргэдэд зориулсан даатгалын зохицуулалтын тогтолцоог сайжруулах зорилготойгоор амжилттай хэрэгжсэн ба одоогоор дээрх зорилгыг үргэлжлүүлэхийн сацуу цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан өсөн нэмэгдэж байгаа эрсдэлийг бичил даатгалын тусламжтайгаар даван туулах асуудалд гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.



RFPI Asia хөтөлбөрийн үйл ажиллагааны гол хэлбэр нь “Төр-хувийн хэвшлийн хэлэлцээр” бөгөөд зохицуулах байгууллага болон даатгалын компаниудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих, хүртээмжтэй даатгалын чиглэлээр тухайн улсад хэрэгжүүлэх шаардлагатай ажил үүргийг хэлэлцэх, нэгдсэн ойлголттой болгох зорилготой. Үүний үр дүнд 2016 оны 7 дугаар сард зохион байгуулагдсан анхны төр, хувийн хэвшлийн хэлэлцээрийн дараа Индонез болон Непал улсууд Филиппинээс суралцсан туршлагаа ажил хэрэг болгож, хүртээмжтэй даатгалын шинэ загварыг бий болгож эхэлсэн. 2017 оны 3 дугаар сард Вьетнам улсад зохион

байгуулагдсан хоёр дахь удаагийн төр, хувийн хэвшлийн хэлэлцээрийн үед Бичил даатгал сэдэвт сургалт, Ази Номхон далайн бүс нутгийн хөгжиж буй улсуудын бичил даатгалыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцсэн юм. Гурав дахь удаагийн хэлэлцээр 2017 оны 09–р сард Монгол Улсад Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан хүртээмжтэй даатгал сэдэвтэйгээр, дөрөв дэх удаагийн хэлэлцээр 2018 оны 01–р сард Филиппин улсад Хүртээмжтэй даатгал ба Цахимжуулалт сэдэвтэйгээр, тав дахь удаагийн хэлэлцээр Шри-ланк улсад Insurtech болон хөдөө аж ахуй, цаг уурын өөрчлөлтийн эрсдэлийн даатгал сэдэвтэйгээр тус тус амжилттай зохион байгуулагдсан.

Үүнээс гадна хөтөлбөрт оролцогч улсуудын дунд цахим хэлбэрээр уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг тогтмол хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал, Tuesdays with MEFIN вэбинарыг 8 удаа зохион байгуулж, хөтөлбөрт оролцогчдыг мэдээллээр хангах, харилцан мэдээлэл солилцох боломжоор хангаж ажилласан.

Хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөрт оролцогч 7 улсад ямар үр дүн гарсныг товчхон дурдвал,

- Зохицуулалт ба хяналт шалгалтын хүрээнд RFPI хөтөлбөрт оролцсоноор 7 улс нь Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбооноос гаргасан аргачлалын дагуу өөрийн улс орны зохицуулалтын орчныг үнэлсэн, мөн хөтөлбөрөөс Хүртээмжтэй даатгал дахь зохицуулалтын орчны нөлөөллийн үнэлгээг хийснээр хөтөлбөрт оролцогч улсууд хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх чиглэлээр цаашид зохицуулалтын орчныг хэрхэн сайжруулах төлөвлөгөө боловсруулахад дөхөм болсон юм. Мөн Индонез улс бичил даатгалын гранд загвар, бичил даатгалын бүтээгдэхүүн ба маркетингийн сувгийн зохицуулалт, Монгол Улс хүртээмжтэй даатгалын тодорхойлолт, бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, Непал Улс бичил даатгалын захирамж /Directives/, Пакистан улс хүртээмжтэй даатгалын болон байгууллагын даатгалын төлөөлөгч болон



технологид суурилсан борлуулалтын сувгийн зохицуулалт, Филиппин улс бичил даатгалын зохицуулалтын орчин болон бичил даатгалын бичил даатгалын үндэсний стратеги, Вьетнам улс бичил даатгалын гарын авлагыг гаргаж ажилласан байна.

- Хүртээмжтэй даатгалд инновацийг бий болгох чиглэлээр хийсэн ажлуудын хүрээнд Филиппин 6, Шри-ланк 1, Непал 4, Пакистан 3, Индонез 4, Вьетнам 2, Монгол 2 нийт 22 бизнесийн загварын танилцуулга /factsheet/ гаргаж, хэвлүүлсэн

байна. Манай улсад анхны урт хугацааны даатгалын “Хорт хавдрын хүртээмжтэй даатгал”–ын бүтээгдэхүүн бүртгүүлж, зах зээл дээр борлуулагдаж эхэлсэн.

- Хөтөлбөрт оролцогчдын чадавхыг сайжруулах чиглэлээр хүртээмжтэй даатгалын талаарх олон улсын хурал, уулзалт, сургалтуудад холбогдох ажилтнуудыг хамруулахад дэмжлэг үзүүлэхээс гадна Financial Literacy Campaign kit, Disaster risk insurance manual, Regulatory impact assessment manual–ийг хэвлүүлсэн.

ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АМЖИЛТТАЙ ХЭРЭГГИЖ ДУУСЛАА



Хүртээмжтэй даатгалын салбарын гол оролцогчдын манлайлал, шинэ санал, санаачлага гаргах чадварыг хөгжүүлэх болон даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх боломжит шинэчлэл, өөрчлөлтийг бий болгох зорилготойгоор ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, Дэлхийн манлайллын академи /GLA/ болон Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэгч Олон Улсын байгууллага /A2I/ хамтран 2017 оны 11 дүгээр сараас 1 жилийн хугацаанд “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх хөтөлбөр”-г Кени, Албани, Гана болон Монгол зэрэг 4 оронд хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрт оролцогч улсууд тус бүртээ Үндэсний багийг бүрдүүлэн ажилласан ба Үндэсний баг нь хүртээмжтэй даатгалыг

хөгжүүлэх, зохистой зохицуулалтын орчныг бий болгох талаар шинэ санаа, санаачлагыг гаргаж, танилцуулах зорилготой. Манай улсын үндэсний багт Санхүүгийн зохицуулах хороо тэргүүтэй Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон даатгалын компанийн төлөөллүүд багтаж байгаа бөгөөд 12 сарын хугацаанд хэрэгжсэн “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөл”-өөр даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг үнэлж дүгнэлт гарган, цаашид хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх боломжууд, авч хэрэгжүүлэх шинэлэг арга хэрэгслүүдийг судалсан.



Хөтөлбөрийн хүрээнд Үндэсний багийн гишүүд 2 удаагийн олон улсын хэлэлцүүлэг, 3 удаагийн үндэсний семинарт оролцож ажилласан бөгөөд манай улсын Үндэсний багт дэмжлэг үзүүлж, олон улсын сайн жишээ, туршлагыг хуваалцахаар Олон Улсын зөвлөх Яннис Крисостомидис болон Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэгч Олон Улсын байгууллагын зөвлөх Оскар Верлиндэн Монгол Улсад ажилласан.



Үндэсний багийн гишүүд хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг хүртээмжтэй болгох, шинэлэг шийдлүүд дээр суурилсан түгээлтийн сувгийг нээх, нэгдсэн


даатгалыг бий болгоход чиглэсэн төрийн зохицуулалтыг сайжруулах зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг тусгасан Монгол Улсын Хүртээмжтэй даатгалын нэгдсэн

стратеги төлөвлөгөө баримт бичиг гаргахаар ажилласан бөгөөд уг баримт бичгийг эцэслэн боловсруулахаар одоог хүртэл ажиллаж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


Хөрөнгийн зах зээл: 2018 онд хөрөнгийн зах зээлд 54 ҮЦК тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. 2018 оны жилийн эцсийн ҮЦК-уудын нийт орлого 13.1 тэрбум төгрөг, нийт зардал 9.5 тэрбум төгрөг, цэвэр ашиг 2.5 тэрбум төгрөг байна. 2018 онд ҮЦК-уудын нийт хөрөнгө 85.4 тэрбум төгрөг байгаа бөгөөд хөрөнгийн бүтцийн 89.9 хувийг эргэлтийн хөрөнгө, 10.1 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлсэн байна.

Зураг 1: Үнэт цаасны компаниудын орлогын болон балансын тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/




Хаа-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл: 2018 онд хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн зах зээлд зуучлалын үүрэг гүйцэтгэх нийт 12 брокерийн компани Хорооноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэлд хамрагдсан компаниудын нийт хөрөнгийн дүн 1.6 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Зураг 2: Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дын тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/




Даатгалын зах зээл: 2018 онд даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 5.2 тэрбум төгрөгөөр буюу 39.7 хувиар өсөж 18.4 тэрбум төгрөг болсон байна. Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан ба 8 даатгалын компани, 50%-хүртэлх өсөлттэй 5 даатгалын компани, 50%-100%-ийн өсөлттэй 1 даатгалын компани, 100%-аас дээш өсөлттэй 3 даатгалын компани байна. Ердийн даатгалын компаниудын татварын дараах цэвэр ашгийн хэмжээ дунджаар 1.9 дахин өсжээ.

Зураг 3: Даатгалын салбарын татварын дараах цэвэр ашиг




Банк бус санхүүгийн байгууллага: Тайлант онд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт орлого өмнөх оноос 32.5 хувиар өсөж 259.5 тэрбум төгрөгт хүрсэн бол, нийт зарлага өмнөх оноос 22.7 хувиар өсөн 158.4 тэрбум төгрөгт хүрчээ. Ингэснээр банк бус санхүүгийн байгууллагуудын нийт цэвэр ашиг өмнөх оноос 51.4 хувиар өсөн 101.1 тэрбум төгрөг болсон байна.

Зураг 4: ББСБ-уудын орлого, зарлага, ашгийн динамик /тэрбум төгрөгөөр/




Хадгаламж, зээлийн хоршоо: Сүүлийн 10 жилийн хугацаанд салбарын нийт орлого, зардал аажмаар өссөөр байгаа ба 2018 онд нийт ХЗХ–д 41.2 тэрбум төгрөгийн орлого, 35.9 тэрбум төгрөгийн зардал, 5.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Харин цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос 4 пунктээр буурч 12.9 хувьд хүрчээ. Салбарын хэмжээнд нийт 279 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаагаас 198 ХЗХ нь 5.6 тэрбум төгрөгийн ашигтай, 73 ХЗХ 0.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 8 ХЗХ үйл ажиллагаа явуулаагүй байна.

Зураг 5: ХЗХ–дын орлого ба зардал /тэрбум төгрөгөөр/




Зээлийн батлан даалтын сан: 2018 оны жилийн эцсийн байдлаар зээлийн батлан даалтын сан 3.8 тэрбум төгрөгийн орлого олж, 1.9 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын 85.9 хувийг гишүүдийн татварын орлого /хүүгийн орлого/, үлдсэн 14.1 хувийг батлан даалт, хураамж, шимтгэлийн орлого бүрдүүлж байна. Тайлант онд Сангийн цэвэр орлогын дүн өмнөх оноос 1.5 дахин өссөн дүнтэй байна.

Зураг 6: Ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/



ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ НЬ

Даатгалын компаниуд технологийн хөгжил, дижитал шинэчлэлүүдтэй холбоотойгоор хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай болж байна. Хиймэл оюун ухаан, роботуудын тусламжтайгаар гар ажиллагаа их шаарддаг ажлуудыг автоматжуулан, хялбарчилж байна мөн үүний зэрэгцээ энэхүү хөгжлийн нөлөөгөөр зарим ажлын байр технологиор солигдож байна. Даатгалын компаниуд технологийн дэвшилтэй холбогдуулан ажилчдаа цаг хугацаа болон ур чадвараа илүү бүтээмжтэйгээр ашиглан шинийг санаачлах, мэргэшүүлэх тал дээр илүү анхаарч ажиллах төлөвтэй байна. Доорх зурагт үзүүлснээр ирээдүйд актуарчид, андеррайтерууд, хохирол үнэлэгчид болон бусад чухал албан тушаалтнууд нь төсөөлөл, таамаглал гаргах гэх мэт илүү стратегийн шинжтэй дээд түвшний асуудлуудад анхаарлаа хандуулан ажиллах болно. Ажиллагсад нь тооцоолол хийх тунгаан бодох зэрэг ажилд бага цаг зарцуулж, шинэ санаа гаргах болон шийдвэр гаргахад илүү их цаг зарцуулан ажиллах чиг хандлагатай байна.



2019 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

5 ДУГААР САРЫН 10,11

Frontier Fintech Summit, Монгол Улс
2019

6 ДУГААР САР

Climate risk management workshop,
Улаанбаатар хот

7 ДУГААР САРЫН 24–26

Олон улсын хоршоодын
зохицуулагчдын сүлжээ (ICURN)–
ний ээлжит чуулган АНУ

5 ДУГААР САРЫН 13–17

Үнэт цаасны хороодын олон улсын
байгууллагын 44 дүгээр ээлжит
чуулга уулзалт, Үндэстнүүдийн
Холбооны Австрали Улс

6 ДУГААР САРЫН 17–20

СХН–ийн Зүүн Европ Төв Азийн
Зөвлөлийн Уулзалт

9 ДУГААР САРЫН 9–13

СХН–ийн ээлжит Дэлхийн бодлогын
форум, Руандагийн Бүгд Найрамдах
Улс

5 ДУГААР САРЫН 29–31

Бичил санхүүгийн төв (MFC) ээлжит
чуулган, Бүгд Найрамдах Турк Улс

6 ДУГААР САРЫН 29

Азийн Insurtech дээд хэмжээний
уулзалт, Бүгд Найрамдах Сингапур
Улс

11 ДҮГЭЭР САР

17th annual conference of the Interna-
tional Association of Insurance Super-
visors /IAIS/ , Abu Dhabi 2019



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо